



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног  
төхөөрөмж /Уншилж хамжасан/ Видоо хуртлийн тоног  
төхөөрөмж худалдан авах

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

ХХААХҮЯ/20240102059

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "бараа" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.

1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орои нутгийн омниийн хориггоор бараа, ожил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

4.1. Төндөр шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийпэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбоогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийпэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.  
6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нехцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж телсэн байна.

6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.



7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалzan үзэхгүй. 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй. 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад өрөлцөх эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
8. Нийлүүлэх барааны гарал үүсэл	8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
9. Тендер шалгаруулалтын баримт бичиг	<p><b>Б.АГУУЛГА</b></p> <p>9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:</p> <p>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;</p> <p>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;</p> <p>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;</p> <p>IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;</p> <p>V Бүлэг. Тендерийн жишиг маягт;</p> <p>VI Бүлэг. Гэрээний нөхцөл.</p> <p>9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцелийг баримтална.</p> <p>9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	<p>10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүснэгтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заясан хаягыар хүргүүлнэ.</p> <p>10.2. ТШЗ 10.1-д заасан хүснэгтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>10.3. Тодрууллын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.</p>
11 Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	<p>11.1 Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуупах, эсхүп ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.</p> <p>11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.</p>
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	<p><b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b></p> <p>12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p>



	<p>12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.</p> <p>12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
13. Тендерийн иж бүрдэл	<p>13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.</p> <p>13.2. Оролцгчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <p>13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p> <p>13.2.2. оролцгчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийн баталгаажуулсан бол холбоидох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p>13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</p> <p>13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан өрөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</p> <p>13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцэнийг нотлох баримт бичиг;</p> <p>13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>13.2.7. тендерт оролцгчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</p> <p>13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;</p> <p>13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдож холбоидох тайлбар,</p> <p>13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.</p> <p>13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p> <p>13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.</p>
14. Тендерийн жишиг маягтууд	<p>14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.</p>
15. Хувилбарт санал	<p>15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерд ирүүлж болно.</p>
16. Өрөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	<p>16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.</p> <p>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p>



16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтээрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 1-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.

17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендert ирүүлэхийг шаардахгүй.

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендert ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг огогдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг төхникийн тодорхойлолттой нийцсөн болохыг хянаа үзэх боломжийн төримт, хэрэв санал болгох бараа төхникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбээ хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;



	<p>17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.</p> <p>17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.</p> <p>17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.</p>
18. Чадавхын болон туршлагын шаардлага	<p>18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.</p> <p>18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p> <p>18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.</p> <p>18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.</p>
19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	<p>19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн ертэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагaa ирүүлэхийг шаардахгүй.</p>
20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	<p>20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.</p>



21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь эн зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцуу гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өргийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
22. Тендерийн валют
- 22.1. Монгол Улсын олон үлсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
23. Тендер хүчинтэй байх хугацаа
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
24. Тендерийн баталгаа
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд тесөвт өргийн 0.5 хувиар тооцсон "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.



	24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ируулнэ.
25. Тендер баталгаажуулах, илгээх	<p><b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b></p> <p>25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.</p> <p>25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ируулэх шаардлагагүй.</p> <p>25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээн бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ируунна.</p> <p>25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээн ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн зэний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p> <p>26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа</p> <p>26.2. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.</p> <p>26.3. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.</p>
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	<p><b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b></p> <p>27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.</p> <p>28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.</p>
27. Тендерийн талаар тодруулга авах	<p>29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.</p> <p>29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.</p>
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	<p>30.1 Тендерийн үнийн арифметик алдааг "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-т зааснаар запруулна.</p> <p>30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг запруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.</p>
29. Тендерийг үнэлэх	<p>31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгох, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.</p> <p>31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.</p>
30. Арифметик алдааг запруулах	
31. Давуу эрх олгох	



	31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер "хамгийн сайн" гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
34. Тендерийг эрэмбэлэх	34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадлаж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
36. Шийдвэр хүргүүлэх	<b>E. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b> 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
37. Гүйцэтгэлийн баталгаа	37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. 37.2. Гүйцэтгэлийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нехеж, оролцогчид хүргүүлнэ. 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.



## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/- Видео хурлын тоног төхөөрөмж худалдан авах</b>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <b>ХХААХҮЯ/20240102059</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Байхгүй”</b>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <b>“Байхгүй”</b>
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн хөрөнгөөр</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>422,874,600.0 (дөрвөн зуун хорин хоёр сая найман зуун далан дөрвөн мянга зургаан зуун төгрөг)</b>

### Б. АГУУЛГА

ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичийг тодруулах хүснэгтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <b>Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга</b> Хаяг: <b>Засгийн газрын 9а дугаар байр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр, 4 дүгээр давхар, 405 тоот өрөө</b> Утасны дугаар: <b>51-262668</b> Цахим шуудангийн хаяг: <b>mofa@mofa.gov.mn</b>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>

### В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх тесөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
ТШЗ 16.1	Ерөнхий шаардлагыг магадлахад шаарддагдах баримт бичиг: <b>“Шаардана”</b>  Төрийн худалдан авах ажиллагааны цахим ситетд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан цахимаар ирүүлэх доорх тодорхойлолтын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ</li><li>- Нийгмийн даатгалын тодорхойлолт</li><li>- Татварын өргүй тодорхойлолт</li></ul>



	<ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн шийдвэрээр өртэй эсэх лавлагаа</li> <li>- Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт</li> </ul> <p>Тендерт оролцогч Териин худалдан авах ажиллагааны цахим системд өөрийн тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж лавлагаа, тодорхойлолтыг авах хүсэлтийг илгээдэг болохыг анхаарна уу:</p>
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <p><b>Барааг угсарч сууринуулан холболт, тохиргоог хийх инженертэй байх</b></p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага:</p> <p><b>2022, 2023 онуудад доод тал нь 3 удаа санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлэх ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх</b></p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>2022, 2023 оны аль нэг жилд нийт борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Түргэн хөрөвөх хөрөнгийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх</li> <li>- Банк санхүүгийн байгууллагад тендер зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх</li> </ul> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>Техникийн тодорхойлолтын дагуу санал болгож буй барааны тодорхойлолтын хүснэгтийг захиалаагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичиж ирүүлэх</b></p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардахгүй”
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Териин худалдан авах ажиллагааны цахим системээр татагдсан санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн</li> </ul>



	<p><i>гүйлгээний тайлангийн лавлагаа /лавлагааг татагдсан эсэхийг нягтлаж илгээнэ үү/</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд 2022, 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт /дансны үлдэгдэл болон авч болох зээлийн тодорхойлолт/</li> <li>- Хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагаа;</li> </ul> <p>Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a>-ээс, зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a>-ээс шалгана.</p> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>Сүүлийн 2 жил /2022, 2023/</b>.</p>
<b>ТШЗ 20.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “<i>Тийм</i>”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Захшалагчийн өгсөн төхникийн тодорхойлолтод нийлүүлэгчийн нийлүүлэх барааны төхникийн тодорхойлолтыг харьцуулсан хүснэгт</li> <li>- Нийлүүлэгчээс санал болгож буй төхникийн тодорхойлолт нийцсэн үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулга</li> <li>- Оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг, бараа нийлүүлэх гэрээ /гадаад хэл дээр бол баталгаат орчуулгын хамт ирүүлэх/</li> <li>- Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;</li> <li>- Оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн тэмдэглэлийн талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> <li>- Сүүлийн 2 жилд доод тал нь 3 удаа санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй нийлүүлсэн ижил төстэй барааны өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;</li> <li>- Санал болгож буй барааны албан ёсны борлуулагчаар сүүлийн 2 жилийн хугацаанд ажилласан байхыг нотлох баримт</li> <li>- Санал болгож буй бараанд засвар үйлчилгээ хийх үйлчилгээний төвтэй эсэхийг нотлох баримт</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Үйлдвэрлэгчийн баталгааг 3-аас доошгүй жилийн хугацаатай санал болгодог байх, чанарын баталгаа үзүүлэх гэрээ, баримтын мэдээлэл, хуулбар, баталгаат орчуулгын хамт</i></li> <li>- <i>Бараа хүргэлтийг нийлүүлэгч компани хариуцах ба гэрээ байгуулахдаа нийлүүлэх өдрийг харилцан тохиролцно</i></li> <li>- <i>Техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 19.1-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох Өгөгдлийн хүснэгтэд заасан бусад баримт.</i></li> </ul> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ <i>Toхируулахгүй тогтолцол байна</i> ”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “ <i>Tийм</i> ” <i>Incoterms 2020, DDP, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар</i>
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: <i>Төсөөстөртгийн 0.5 хувь 2,114,373.0 төгрөг</i>

#### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2, 29.3-д заасны дагуу баримт бичиг, материалтай танилцаж болно.</i>
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр</i> Цаг: <i>11 цаг 00 минут</i>
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <i>2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр</i> Цаг: <i>11 цаг 20 минут</i> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 4 дүгээр давхар, 405 тоот өрөө</i>

#### Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “ <i>Үгүй</i> ”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: “ <i>Шаардахгүй</i> ”
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “ <i>Ашиглахгүй</i> ”



### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглаадаасүй, сүүлийн үсийн тохиолоси зориийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.



### **Зураг, төсөл**

*Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.*

### **Шалгалт, туршилт**

*[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.]*

*Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцозшид буцааж олгохсүй тухай тохишикийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.*

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*



## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолтод нийцсэн байна.  
**Санал болгож буй техникийн тодорхойлолт хэсэгт захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүйгээр зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг, Тайлбар хэсэгт санал болгосон үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг заавал хавсаргана.**

**Барааны нэр: Video wall Screen 55" /угсардаг дэлгэц/**

№	*	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ уу.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Загвар /модель/: Video Wall Screen эсхүл түүнтэй дүйцэх		
2	Загварын өндөр зураг /150x150 pixels/		
3	Гарал үүсэл:		
4	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:		
5	Үйлдвэрлэсэн он: 2022 оноос хойш		
6	Video Wall Screen Led550P18 Display 55" 1.8mm хүрээтэй, Гэрэлтэлт - 500cd/m2, Хэмжээ - 121.5x685.5x5.72 4J UHD		
7	Displays more vivid and detailed content EDL technology for ultra-high consistency		
8	Бүрэн дэлгэцийн өндөр нарийвчлал, өнгөний өндөр тодосогчтой, нүдний хамгаалалтаар сайжруулсан, ашиглалтын болон зогсолтын горимд эрчим хүч хэмнэх технологи		
9	Баталгаат хугацаа: Үйлдвэрлэгчийн баталгаа 1 жилээс доошгүй		

**Барааны нэр: Компьютер, touch дэлгэцтэй илтгэгчийн цахим индэр**

№	*	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ уу.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Загвар /модель/: УХААЛАГ ИНДЭР SP-Y670 эсхүл түүнтэй дүйцэх		
2	Загварын өнгөт зураг /150x150 pixels/:		
3	Гарал үүсэл:		
4	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:		
5	Үйлдвэрлэсэн он: 2022 оноос хойш		
6	21 ичийн мэдрэгчтэй ALL-IN-ONE компьютер		
7	Компьютерын үзүүлэлт нь i5- 8250CPU/8GBRAM/256GB SSD		
8	Wireless хүлээн авдаг байх		
9	Үйлдлийн систем: Windows 10		
10	Дэлгээний нягтрал: 1920 x 1080 Дэлгээний хэмжээ: 21 inch, мэдрэгчтэй байх		
11	Нэмэлт шаардлага: Индэрийн дэлгэц дээр зурж тэмдэглэл хийж болдог байх, индэрийн зориулалтын зөөврийн дугуйтай байх, индэр нь өндөрөө автоматаар тааруулдаг байх.		



12	Гадаргуу дээр нь микрофон болон гэрлийн залгуур суурилуулсан		
13	Индэр дээрээ илтгэгчийн микрофон суурилагдсан, USB, интернет, VGA, HDMI (Power, Go Up, Go Down, Microphones Switch)		
14	Илтгэгч өөрийн өндөрт тохируулан удирдах, Ухаалаг самбар, дэлгэц, проектортой холбох боломжтой, Дэлгэц дээрх мэдээллийг индэр дээрээс удирдах, илтгэгч өөрийн микрофоныг удирдах боломжтой *		
15	Баталгаат хугацаа: Үйлдвэрлэгчийн баталгаа 1 жилээс доoshgүй		

#### Барааны нэр: Ухаалаг дэлгэц 86"

№	Захиалаасчийн төхникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалаасчийн төхникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны төхникийн тодорхойлолтыг бичнэ уу.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нийтийн баримт бичиг болон танилцууллыг хавсаргана)
1	Загвар /модель/: T-Panda 86" эсхүл түүнтэй дүйцэх		
2	Загварын өнгөт зураг /150x150 pixels/:		
3	Горол үүсөл:		
4	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:		
5	Үйлдвэрлэсэн он: 2022 оноос хойш		
6	Multifunction Copier + Canon DADF-BA1		
7	Multi-Touch TV&PC, Camer with microphone, I7CPU11GEN, 16GBRAM, 512SSD Hard, Dual system, Windows 10 & Android 8.0, мэдрэгчтэй, Утасгүй гар, хулгана, тэжээлийн залгуур, зориулалтын үзэг 2 ш, заагч, хананд тогтоогч, Wifi хүлээн авагчтай, хөлний хамт		
8	Баталгаат хугацаа: Үйлдвэрлэгчийн баталгаа 1 жилээс доoshgүй		

#### Барааны нэр: Дэлгэц 86"

№	Захиалагчийн төхникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн төхникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болаож буй барааны төхникийн тодорхойлолтыг бичнэ уу.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцууллыг хавсаргана)
1	Загвар /модель/: Canon IR-ADV 4725I эсхүл түүнтэй дүйцэх		
2	Загварын өнгөт зураг /150x150 pixels/:		
3	Гарал үүсэл:		
4	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:		
5	Үйлдвэрлэсэн он: 2022 оноос хойш		
6	TV HDMI оролттой тогтоогч, мэдрэгчгүй		
7	Баталгаат хугацаа: Үйлдвэрлэгчийн баталгаа 3 жилээс доoshgүй		

#### Барааны нэр: Онлайн хурлын камер

№	Захиалагчийн төхникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн төхникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон



		анхаарна уу. Зөвхөн санал болгож буй баааны техникийн тодорхойлолтыг бичнэ уү.)	танилцуулгыг хавсаргана)
1	Загвар /модель/:		
2	Загварын өнгөт зураг /150x150 pixels/:		
3	Гарал үүсэл:		
4	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:		
5	Үйлдвэрлэсэн он: 2022 оноос хойш		
6	usb HD 1.1/2.7 HD color CMOS 10x zoom + USB уртасгач 5 м		
7	Баталгаат хугацаа: Үйлдвэрлэгчийн баталгаа 3 жилээс доошгүй	.	.

**Барааны нэр: Холбогч уртасгач кабел, холболтын төхөөрөмж**

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй баааны техникийн тодорхойлолтыг бичнэ уү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	HDMI Splitter 4x2		
2	HDMI V2.0 кабель 20м 4 ширхэг		
3	Аудио кабель 80м боодол		
4	Mic to PC Aux cable 10m		
5	PC to Amplifier Aux кабель 10м		

**Барааны нэр: Хурлын заалны тоног төхөөрөмжийг суурилуулах ажил**

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй баааны техникийн тодорхойлолтыг бичнэ уү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Яамны том хурлын зааланд 9 ширхэг 55", 2 ширхэг 86" дэлгэцийг зай завсаргүй, тэгшээн угсарч суурилуулах, дэлгэц байрлуулах хана нимгэн тул даацын хана шинээр угсарч байршуулах, удирдлагын өрөө эсвэл рак байрлуулан хурлын өрөөний дууны төхөөрөмж, удирдлагын төхөөрөмжийг байрлуулан ил гарах кабелуудыг далдлах зэрэг ажлыг хийж егнэ.		



## Бараа нийлүүлэлтийн хуваары

[Захалагч доорх хүснэгтийн 1-6 хуртэлх бөвлийн, төндөрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

				Бараа нийлүүлэлтийн хуваараа		
No	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан бараат хүстэх эцсийн цэг бөглөнө)	Захалагч бараа хулээн авах хувацаа (эхлэх болон дусах хувацаа)	Нийлүүлэлтийн санал болгох хувацаа (Фролцогч энэ баганыг бөглөнө)
1	Video wall Screen 55" /угсардаг дэлгэц/	9	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
2	Компьютер, touch дэлгэцэй илтгэгчийн цахим индэр	2	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
3	Ухаалаг дэлгэц 86"	27	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа Байгууллага, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
4	Дэлгэц 86"	1	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
5	Онлайн хурлын камер	1	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
6	Холбогч уртасагч кабел, холболтын техөөрөмж	1	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]
7	Хурлын заалны тоног техөөрөмжийг сууринуулах ажил	1	ш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7-60 хоног	[6 дугаар баганад заасан хувацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хувацаааг бичих]

## IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### IV.1.“Чанар ба үнийн хосолмол” тендер үнэлэх үндсэн шалгуур

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах чанар ба үнийн хосолмол шалгуур (Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад тус тендер үнэлэх үндсэн шалгуурыг тендер шалгаруулалтын баримт бичгээс хасна)

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ ( $P_{min}$ )-тэй тендерт 30 оноо ( $S_{max}$ ) өгч, бусад оролцогчийн харьцуулах үнэ ( $P_x$ )-д харгалзах оноог дараах томьёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

$P_{min}$ —Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн үнэ

$P_x$ —Тухайн оролцогчийн үнэ

$S_x$ —Тухайн оролцогчийн оноо

$S_{max}$ —Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн оноо

#### 2. Эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

- |  |        |
|--|--------|
| 2.1. Эм нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:  | 8 оноо |
| 2.2. ДЭМБ-ын эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшингээр 4-т жагссан улсад үйлдвэрлэгдсэн бол  | 8 оноо |
| 2.3. Эм нь хатуу зохицуулалттай улсад үйлдвэрлэгдсэн бол (SRA, PICS):  | 8 оноо |
| 2.4. Импортын эм нь үйлдвэрлэгч улсад хэрэглэдэг бол (чөлөөт худалдааны гэрчилгээ)   | 6 оноо |
| 2.5. Ерөнхий нэрилийн эмийн хувьд биозеквиалент чанарын судалгааг хөндлөнгийн эрх бүхий судалгааны байгууллагын хийлгэсэн бол (Цусан дахь эмийн идэвхт бодисын хамгийн их концентраци ( $S_{max}$ ) 80 - 125%) | 6 оноо |
| 2.6. Үйлдвэрлэгч нь ДЭМБ-ын эм үйлдвэрлэлийн зохистой 6 оноо дадал (GMP) хангасан гэрчилгээтэй бол   | 6 оноо |
| 2.7. Эм нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан бол   | 4 оноо |
| 2.8. Эм нь Англи, АНУ, Европ, Япон, БНХАУ, ОХУ-ын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол  | 4 оноо |
| 2.9. Эм нь АНУ-ын бүртгэлтэй эмийн жагсаалт “Orange Book”-д орсон бол  | 4 оноо |
| 2.10. Эм нь ДЭМБ-ын харьцуулах бүтээгдэхүүний жагсаалтад орсон бол   | 4 оноо |
| 2.11. Ахдагч буюу оригинал эм бол  | 4 оноо |
| 2.12. Ханган нийлүүлэгч нь өөрөө импортлогч бол  | 4 оноо |
| 2.13. Тухайн эм нь сүүлийн нэг жилд лабораторийн шинжилгээгээр стандарт бус гаралгүй бол   | 2 оноо |



2.14. Эмийн аюулгүй байдлын хугацаат тайланг (PSUR)	2 оноо
сүүлийн 2 жилийн хугацаанд эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлсэн бол	
Нийт	70 оноо
<b>3. Эмнэлгийн хэрэгслийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:</b>	
3.1. Үйлдвэрлэгч нь ISO 13485 стандартын шаардлага хангасан бол	15 оноо
3.2. Импортын эмнэлгийн хэрэгсэл нь үйлдвэрлэгч улсдаа хэрэглэдэг бол (FREE SALE CERTIFICATE)	15 оноо
3.3. Эмнэлгийн хэрэгсэл нь гурав ба түүнээс дээш улсад нийлүүлэгддэг бол	15 оноо
3.4. Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн сайн дадал (Good manufacturing practice) гэрчилгээтэй бол	15 оноо
3.5. Үйлдвэрлэгч нь ISO 9001 стандартын шаардлага хангасан бол	10 оноо
Нийт	70
4. Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурт нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.	

$$B_x = Q_x + S_x$$

Bx – Тухайн оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Qx – Тухайн оролцогчийн чанарын үнэлгээний оноо

## IV.2. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 29.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлсан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа хүрээх, ажил, үйлчилгээ дууогох хугацаа: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарыт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлсан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн



хуваарыт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бичих]—аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас [тоо бичих]—аас илүү [“*сар*”, “*өдөр*” гэдэг үгнээс *сонгож бичих*] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.*]

Хэрэв “ashiглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.*]

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.*]

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэпазэнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байзалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засэйн үр ашигтай хэрэглээний тогтоортой байдлыг хангах, байгаль орчиши, хүний эрүүл мэндэд сорөз нөлөөзүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлж болно.



**Жишиг нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт**

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үнэлгээ</b>
<b>I</b>	<b>Нийгмийн шалгуур</b>	<b>Хамгийн их оноо (-5%)</b>
1.1	Олон улсын хөдөлмөрийн стандарт, ОУХБ-ын Суурь конвенцыг дагаж мөрдөж буй байдал	
1.2	Ажиллах хүч / ажил эрхлэлтийн харилцаа	
1.3	Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал	
1.4	Шударга цалин хөлс болон хөдөлмөрийн харилцаа	
1.5	Ажиллах орчны аюулгүй байдал	
1.6	Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ажил эрхлэлт	
<b>II</b>	<b>Эдийн засгийн шалгуур</b>	<b>Хамгийн их оноо (-5%)</b>
2.1	Бизнесийн ёс зүй (Ёс зүйн код)	
2.2	Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дэмжлэг	
2.3	Тээвэрлэлт/хүргэлт	
2.4	Хаяж устгах (Биетээр татан авах эсвэл аюулгүй байдлаар устгах)	
<b>III</b>	<b>Байгаль орчны тогтвортой байдлын шалгуур</b>	<b>Хамгийн их оноо (-10%)</b>
3.1	Байгаль орчны хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал (ISO 14001)	
3.2	Компанийн чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001)	
3.3	Таримал ойгоос бэлтгэсэн, эсхүл дахин боловсруулсан цаас	
3.4	Энгийн хлор агуулаагүй	
3.5	Цайралт	
3.6	Байгаль орчинд ээлтэй савлагаа	
3.7	Дахин боловсруулах боломжтой	

Дээрх үнэлгээний шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тендерт оролцогчийн санал болгож буй үнийг (-20) хувь хүртэл нэмэгдүүлж харьцуулах үнийг тодорхойлно. Уг үнэ нь зөвхөн харьцуулах зорилготой. Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-яас танилцуулах бопомжтой.



## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Т.ЖАМБАЛЦЭРЭН ТАНАА**

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиин /1.-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаалт эрхэлж Байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш,
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
  - 2.4. Оролцгчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийз хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу төндер нээнээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртэх үндэслэл болцлуулж хүчээн зөвшөөрч байна.
7. Төндерт санал болгосон бараа нь оюуны өмчин зөрчилгүй, эрхийн болон биет бийдлийн дигодолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна." гэж сольж бичнэ үү.



Барааны үнийн задаргаа

*[Итгээмжлэл гүйцэтгэх төлөвлөх эрх бүхий эмсээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын*

mama, madre;

Монгол Улсын Төслийн бичигийн даруйчилсан багасаны газар уснын нотлог хавсаргана.

## Маягт 3

**Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

## Маягт 4

**Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

## Маягт 5

**Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дүгнэр
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)
	<input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

## Маягт 6

**Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		



## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний өрөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГФН-ийн олон нийгмийн тодорхой мэдээллийг ГТН-д түгэхэн олон олон бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн олон нийгмийг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон "хамгийн сайн" үнэлгэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохиорох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлеес урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.



## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. "Бараа" гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. "Дагалдах үйлчилгээ" гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. "Захиалагч" гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. "Нийлүүлэгч" гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. "Толууд" гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. "Хууль" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. "Бараа нийлүүлэх нөхцөл" гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. "Бараа нийлүүлэх газар" гэж барааг хүлээлгэн егөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. "Доголдол" гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. "Баталгаат хугацаа" гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. "Гомдлын шаардлага гаргах хугацаа" гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлагат гаргах хугацааг;
  - 1.1.12. "Захиалагчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.13. "Нийлүүлэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар



		Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
	1.1.14.	“Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхуй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
Гэрээний тайлбар	1.2.	Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
	1.2.1.	Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
	1.2.2.	Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
	1.2.3.	Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмын өвримжлэлан тайлбарлана.
	1.2.4.	Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
	1.2.5.	Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
		<b>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</b>
Бараа нийлүүлэх	2.1	Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
	2.2	Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3	ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4	Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг үүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Бараа нийлүүлэх газар	2.5	Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.



Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана. 2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
Барааг хүлээлгэн өгөх	2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно. 2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Барааны гарал үүслийн улс	2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Баглаа боодол	2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийн нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Худалдааны нөхцөл	2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана. 2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах серөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Гүйцэтгэлийн баталгаа	2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарын дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ. 2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.



- 2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:
- 2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
  - 2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
  - 2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

#### **ГУРАВ. ЗАХИАЛАГЧ**

Барааг хүлооюу авах

- 3.1 Захиалагч нь барааг хүлооюу авч, хүлоолцооюу баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

- 3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

- 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

- 3.9 Захиалагч нь төлберийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлберийг Нийлүүлэгчид төлнэ.

- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгагдсан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлберийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.



- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс сүутгана.

#### **ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**

Захиалагчийн хүлээх эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>* 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>4.1.1. Барааг—захиалагчид—шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</li> <li>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</li> </ul>
Даатгал	<ul style="list-style-type: none"> <li>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</li> </ul>
Доголдол	<ul style="list-style-type: none"> <li>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</li> <li>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</li> <li>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</li> <li>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</li> <li>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</li> <li>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар телнэ.</li> <li>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас сүутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар телнэ.</li> </ul>
Чанарын баталгаа	<ul style="list-style-type: none"> <li>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</li> <li>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</li> <li>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</li> </ul>



	4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мэнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
	4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
	4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мэнгийг Нийлүүлэгчид олгоно.
	4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
Алданги	4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зерчих	4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зерчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хулээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шийдвэртэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
	4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
	4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
	4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
	4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд негеө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
	4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.



## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах,  
гэрээг цуцлах үндэслэл

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
  - 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
  - 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
  - 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
  - 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
- 5.2. Нийлүүлэгч тендert оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээ дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

### ЗҮРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч

- 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
- 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

- 6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендert зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.



Нууцлал	6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
Мэдэгдэл	6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ. 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нехцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ. 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ. 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно: 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлеелөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн. 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг модогдоогүй тал хариуцна. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна: 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.15.2. үнийн тохируулга хийсэн. 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтэд талуудын эрх бүхий толооллогч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
Маргаан шийдвэрлэх	6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.



## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: <i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа байгууллага, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар</i>
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулснаас хойш 7 буюу түүнээс дээш хоног</i>
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: <i>Барааг эцсийн цэгт хүлээж авахын өмнө уг бараа тендерийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана. Шалгалтыг захиалагч тал, нийлүүлэгч талтай нийлүүлэгч талын зардлаар хийж гүйцэтгэнэ. Бараа нийлүүлэх газарт тоног төхөөрөмжийг нийлүүлэгч тал угсарч сууринуулан, холболт тохиргоог хийж өгнө.</i>
ГЕН 2.14.	Баглаа, боодол: <i>Барааны дагалдах баримт бичгийг /барааны нэр, жагсаалт, тоо хэмжээ, заавар, зарлагын баримт, нэхэмжлэл/ бүрэн дагалдуулах Шаардлага хангасан баглаа боодолтой байх</i>
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: <i>Incooterms 2020, DDP</i>
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал: “Хийхгүй”
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: <i>Гэрээний нийт үнийн дүнг бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн тэмдэглэл зэргийг үндэслэн төлнө.</i>
ГЕН 4.2.	Даатгал: “Үгүй”
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: <i>Үйлдвэрлэгчийн баталгаа 3 жил</i>
ГЕН 4.11	Чанарын баталгаа: “Шаардахгүй”
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох осох: “Тийм” Алдангийн хувь: <i>Хоног тутамд 0.05 хүртэл хувиар</i>
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Үгүй”



## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид "нийлүүлэгч" гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Бараа" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Техникийн тодорхойлолт;
  - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий отгоодууд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан;
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_



## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо:	<b>2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр</b>
Тендер шалгаруулалтын төрөл:	Бараа
Тендер шалгаруулалтын нэр:	<b>Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/- Видео хурлын тоног төхөөрөмж худалдан авах</b>
Тендер шалгаруулалтын дугаар:	<b>ХХААХҮЯ/20240102059</b>
Нийт төсөвт өртөг:	<b>422,874,600.0 (дөрвөн зуун хорин хоёр сая найман зуун далан дөрвөн мянга зургаан зуун төгрөг)</b>
Тендер шалгаруулалтын арга:	Нээлттэй

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тоңдор шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “Үеүй”
- Тендерийг **2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс өмнө** тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн, 11 цаг 30 минутанд** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”
- Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: “Тийм” Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үеүй”.
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “Үеүй”
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр төндөр илгээх эрхтэй байна.

Хаяг: 13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын 9а дугаар байр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр, 4 дүгээр давхар, 405 тоот өрөө,  
утасны дугаар: 51-262668, цахим шуудангийн хаяг:  
[mofa@mofa.gov.mn](mailto:mofa@mofa.gov.mn)

